



ХОТ БАЙГУУЛАЛТ,  
БАРИЛГА, ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
САЛБАРЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ  
БЯМБА-ОЧИРЫН МӨНХБАЯРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Тайлан хянасан:**

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Тэмдэг

**Тайлан гаргасан:**

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
САЛБАРЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, НЭГДСЭН  
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ

(албан тушаал)

**Нэгжийн дарга**

/О.ОДБАЯР/

(гарын үсэг)

20... ..

**Албан хаагч**

/Б.МӨНХБАЯР/

(гарын үсэг)

20... ..

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
САЛБАРЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ  
БЯМБА-ОЧИРЫН МӨНХБАЯРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д  | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин   |   |  |                          |                 |
|--|--|------------------|---|---|--|--------------------------|-----------------|
|  |  |                  | Суурь түвшин  | Хүрэх түвшин  | Хүрсэн түвшин (биелэлт)  | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|  |  |                  | 1   | 2   | 3  | 4                        | 5               |
| <b>Стратегийн зорилт: Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;<br/>Зорилт 1.1.Сайдын эрхлэх асуудлын хүрээний нэгдсэн бодлого, төлөвлөлт, бодлогын нэгдсэн удирдамжаар хангах;</b> |  |                  |   |   |  |                          |                 |
| 1.   | Арга хэмжээ № 1.1.1 УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Тайлан-1         | Урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хэрэгжилт 75.2 хувьтай. | УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана. | Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/3349 дүгээр албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх ажлыг эхэлсэнтэй холбогдуулан УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ийн | 2025.01.01-2025.12.31    | 100             |

|    |  |          |  |   |   |                       |     |
|----|--|----------|--|---|---|-----------------------|-----|
|    |  |          |  |   | үзүүлэлт тус бүрээр хүрсэн түвшинг өссөн дүнгээр нэгтгэн тайлагнаж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.   |                       |     |
| 2. | Арга хэмжээ № 1.1.2. УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Тайлан-1 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2024 оны суурь түвшнээс 10% нэмэгдүүлсэн байна.  | Дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана.  | Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05/... дугаар албан бичгээр Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 2025.01.01-2025.12.31 | 100 |
| 3. | Арга хэмжээ № 1.1.3. "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.     | Тайлан-1 | "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний | "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05/... дугаар албан бичгээр Салбарын хяналт-шинжилгээ,       | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|    |  |          |  |  |   |                       |     |
|----|--|----------|--|--|---|-----------------------|-----|
|    |  |          | хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 95.71 хувьтай.   | хүргүүлж ажиллана.   | үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.  |                       |     |
| 4. | Арга хэмжээ № 1.1.4. УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Тайлан-1 | “Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг УИХ-ийн 218 дугаар тогтоолоор баталсан. | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана. | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан хөгжлийн төслүүдийн хэрэгжилт болон цогц мэдээлийг medgov.work төслийн цахим маягтаар дамжуулан илгээж, маягтын дагуу нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 02/3118 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яам нь Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан хөгжлийн төслийг хэрэгжих боломжоор нь жагсаалт гаргаж, үнэлж эрэмбэлсэн. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан хөгжлийн төслүүдээс тэргүүн ээлжид хэрэгжүүлэх төслийн жагсаалтад яамны хөгжлийн төслүүдийг нэмж тусгуулахаар холбогдох саналыг бэлтгэн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/3446 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яам “Монгол Улсын Засгийн | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|    |   |          |  |   |   |                       |     |
|----|---|----------|--|---|---|-----------------------|-----|
|    |   |          |  |   | газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан хөгжлийн төслийг хэрэгжих боломжоор нь жагсаалт гаргаж, үнэлж эрэмбэлэн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.   |                       |     |
| 5. | Арга хэмжээ № 1.1.5. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.   | Тайлан-1 | "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" УИХ-ын 35 дугаар тогтоолоор баталсан.            | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана.   | Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн тайланг нэгтгэн Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05/... дугаар албан бичгээр Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.  | 2025.01.01-2025.12.31 | 100 |
| 6. | Арга хэмжээ № 1.1.6. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Тайлан-1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын стратеги төлөвлөгөөг 2025 онд баталсан. | "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028" оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлж ажиллана. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 132 дугаар тушаалын хавсралтаар баталсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/117 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хуваарь"-т заасны дагуу хэрэгжилтийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|    |   |   |   |   |  |                       |     |
|----|---|---|---|---|--|-----------------------|-----|
|    |   |   |   |   | тайлагнаж Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.   |                       |     |
| 7. | <p>Арга хэмжээ № 1.1.7.<br/>Монгол Улсын Ерөнхий сайдын “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 2025 оны 01 дүгээр, “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.</p> | -Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө- 1 -Тайлан-2 | - | Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, холбогдох тайланг ЗГХЭГ-г хүргүүлсэн байна. | <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний төлөвлөгөөг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 177 дугаар тушаалаар батлуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/3261, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны 01/3682, 2025 оны 11 дүгээр 06-ны 01/4107, 2025 оны 12 сарын 01-ны өдрийн 01/4415 дугаар албан бичгээр тус тус Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 01/3070 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> | 2025.01.01-2025.12.31 | 100 |
| 8. | <p>Арга хэмжээ № 1.1.8.<br/>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025-2028 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг</p>   | -Батлуулах үзүүлэлт- 1 -Тайлан-1                    | - | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025-2028 оны   | <p>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 2025-2028 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн төслийг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн</p>  | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|    |   |         |   |  |  |                       |     |
|----|---|---------|---|--|--|-----------------------|-----|
|    | <p>шинэчлэн боловсруулж батлуулах, Барилга, хот байгуулалтын яамны 2021-2024 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах.</p>   |         |   | <p>“Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. Барилга, хот байгуулалтын яамны 2021-2024 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг холбогдох газарт хүргүүлж ажиллана.</p> | <p>хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй уялдуулан шинэчлэн боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-аас “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн биелэлт хасагдсан тул батлуулах шаардлагагүй болсон. Яамны 2021-2024 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05/... дугаар албан бичгээр Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.</p> |                       |     |
| 9. | <p>Арга хэмжээ № 1.1.9. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-д төсөл, арга хэмжээг тусгуулах ажлыг зохион байгуулах.</p> | Санал-2 | <p>“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан.</p> | <p>“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-д</p>   | <p>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлж Монгол Улсын дунд хугацааны, төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлтийн арга зүйд тулгуурлан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн</p>   | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|  |  |  |  |   |  |  |
|--|--|--|--|---|--|--|
|  |  |  |  | <p>төсөл, арга хэмжээний саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байна.</p> | <p>даргын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/109 дугаар тушаалаар байгуулсан. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/13 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсыг болон аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл боловсруулах аргачлал”-ын дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, хэрэгцээ, асуудал, асуудлыг шийдвэрлэх арга зам /стратеги/-ыг тодорхойлж урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 01/2968 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулах хэлэлцүүлэгт 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр, 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрүүдэд Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/109 дугаар тушаалаар байгуулагдсан үндсэн чиглэлийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд болон салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, харьяа байгууллагын төлөөллүүд оролцсон. Монгол Улсын дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн</p> |  |
|--|--|--|--|---|--|--|

|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  | <p>баримт бичиг болох “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд саналаа 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/3740 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны тусгагдаагүй саналын мэдээлэл, тайлбарыг бэлтгэн Төрийн нарийн бичгийн дарга болон Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргад 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр танилцуулж, Эдийн засаг, хөгжлийн яамнаас 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан уг тогтоолын төслийн хэлэлцүүлэгт танилцуулж, холбогдох төсөл арга хэмжээг нэмж тусгуулсан. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төсөлд туссан салбарын үр дүн болон төсөл арга хэмжээний танилцуулга мэдээллийг бэлтгэн 2025 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Сайд, Сайдын зөвлөх, Төрийн нарийн бичгийн дарга болон газар, хэлтсийн удирдлагуудад танилцуулсан. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төсөлд тусгагдсан Хот байгуулалт, барилга, орон</p> |  |
|--|--|--|--|--|--|--|

|  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  | <p>сууцжуулалтын яамны “Инженерийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна”, “Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ” гэсэн үр дүнгүүдийн хүрээнд бодлогын өөрчлөлт, хийж хэрэгжүүлэх ажлыг танилцуулсан танилцуулга мэдээллийг бэлтгэн 2025 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд яамны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчилсан.</p> <p><a href="https://mcud.gov.mn/a/1669">https://mcud.gov.mn/a/1669</a>,<br/><a href="https://mcud.gov.mn/a/1671">https://mcud.gov.mn/a/1671</a></p> <p>“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хавсралт баримт бичиг болох “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-д тусгах төсөл, арга хэмжээний саналаа Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал”-ын хавсралт загвар, маягтын дагуу боловсруулж <a href="http://www.invest.gov.mn">www.invest.gov.mn</a> цахим системээр дамжуулан бүртгүүлж, цахим системд бүртгүүлсэн тусгах төсөл, арга хэмжээний товч мэдээллийг гарган 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 01/3123 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар<br>(арга хэмжээ)   | Шалгуур<br>үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин                 | Хүрсэн түвшин (биелэлт)   | Эхэлсэн,<br>дууссан<br>хугацаа | Биелэлт<br>ийн<br>хувь |
|-----|--|---------------------|--------------|------------------------------|---|--------------------------------|------------------------|
| 1.  | Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах. | Төлөвлөгөө-1        | -            | Тайлангийн хэрэгжилтийн хувь | Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 59 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 6.1-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 2025.01.16-ны өдрийн 11/187 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн ээлжит хурлыг зохион байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу Төрийн албаны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох албан хаагчдын мэдээллийг нэгтгэн 2025.01.15-ны өдрийн 01/170 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн “Хүний нөөцийн үйл | 2025.01.01-<br>2025.12.31      | 100                    |

|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  | <p>ажиллагаанд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 479 дүгээр тогтоол, ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03/355 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 159 дугаар тушаал 2025 оны “Төрийн албаны өдөр”-ийг угтан зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон 2025 оны 15 дугаар тушаал “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл аяныг зохион байгуулах тухай”-уудаар баталсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргаар яамны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Төрийн албаны өдөр-2025”-ийг угтах арга хэмжээний төлөвлөгөө болон “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албан хаагчдын төрийн албанд ажиллахын давуу талыг илэрхийлсэн 3 видео контентийг ТЗУГ-тай хамтран бэлтгэн яамны цахим сүлжээ болон Төрийн албаны зөвлөлийн цахим сүлжээнд байршуулж олон нийтэд хүргэсэн. "Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн хүний нөөцийн</p> |  |
|--|--|--|--|--|--|--|

|  |  |  |  |  |   |  |
|--|--|--|--|--|---|--|
|  |  |  |  |  | <p>аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-д заасны дагуу эрхэлсэн түшмэлийн 3 сул орон тоо, ахлах түшмэлийн 5 сул орон тоо, дэс түшмэлийн 10 сул орон тоог яамны цахим хуудас болон зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, албан тушаалын тусгай шаардлагыг хангаж буй иргэдийг томилж, нөхөгдөөгүй сул орон тооны сонгон шалгаруулалтын явуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажилласан.</p> <p>Тус яамны эрхэлсэн түшмэлийн албан тушаалын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн даргын сул орон тоог нөхөх шалгалт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 03/2010 дугаартай албан бичиг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий санхүүчийн сул орон тоог нөхөх шалгалт, сонгон</p> |  |
|--|--|--|--|--|---|--|

|  |  |  |  |  |   |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|
|  |  |  |  |  | <p>шалгаруулалтыг зохион байгуулах тухай 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 03/1106 дугаартай албан бичгийг Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн байна.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2024 оны “Ажлын хэсэг байгуулах” тухай 03 дугаар тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг тус яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбарын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтад оролцсон 3 иргэнийг нэр дэвшүүлж, санал болгосон.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны “Ажлын хэсэг байгуулах” тухай 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг тус яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбарын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанд</p> |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|

|  |  |  |  |  |   |  |
|--|--|--|--|--|---|--|
|  |  |  |  |  | <p>танилцуулж, салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтад оролцсон 3 иргэнийг нэр дэвшүүлж, санал болгосон. Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны “Ажлын хэсэг байгуулах” тухай 08 дугаар тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалт зохион байгуулах ажлын хэсэг тус яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбарын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, салбар зөвлөлөөс сонгон шалгаруулалтад оролцсон 5 иргэнийг нэр дэвшүүлж, санал болгосон. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай нийтлэг журам”-ын дагуу төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж батлах зөвшөөрөл авахаар 2025.09.23-ны өдрийн 01/3615 дугаар албан бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025.10.29-ний өдрийн ээлжит хуралдаанаар албан тушаалын тодорхойлолт, Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны</p> |  |
|--|--|--|--|--|---|--|

|  |  |  |  |  |   |  |
|--|--|--|--|--|---|--|
|  |  |  |  |  | <p>дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2025.10.29-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 458, 459, 460, 461 дугаар тогтоолууд албажиж, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.11.19-ний өдрийн Б/199, Б/200, Б/201, Б/202 дугаар тушаалуудаар “Албан тушаалын тодорхойлолт”-ыг баталгаажуулсан. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”-ын талаар мэдээлэл өгөх, арга зүйн сургалтад 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр хамрагдаж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт”-ын тайлан, мэдээг нэгтгэн гаргаж шалгуулан бүрэн хангалттай үнэлэгдсэн. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газраас 2025.11.06-09-ний өдрүүдэд хийгдсэн хүний нөөцийн гүйцэтгэлийн аудитын ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, судалгаа, холбогдох нотлох баримтуудыг нэгтгэн гаргаж хүргүүлсэн. Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын</p> |  |
|--|--|--|--|--|---|--|

|    |   |              |   |                              |   |                       |     |
|----|---|--------------|---|------------------------------|---|-----------------------|-----|
|    |   |              |   |                              | “Албан тушаалын тодорхойлолт”-ыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу шинэчлэн боловсруулж, холбогдох танилцуулга, мэдээллийг бэлтгэн 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 01/3067 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.  |                       |     |
| 2. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах. | Төлөвлөгөө-1 | - | Тайлангийн хэрэгжилтийн хувь | Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээллийг тус тус Ёс зүйн хороонд 2025.01.23-ны өдрийн 08/285 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Ёс зүйтэй төрийн албан хаагч, манлайлалтай Ёс зүйн дэд хороо гэсэн уриаг дэвшүүлэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Ёс зүйн дэд хорооны даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээллийг 2025 оны 06 | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|    |   |                          |   |  |   |                       |     |
|----|---|--------------------------|---|--|---|-----------------------|-----|
|    |   |                          |   |  | <p>дугаар сарын 24-ний өдрийн 08/2455 дугаар албан бичгээр Ёс зүйн хороонд хүргүүлсэн. Ёс зүйн хорооны 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 4/223 дугаар албан бичгийн дагуу “Төрийн албан дахь ёс зүйн зөрчил: шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тандах судалгаа”-нд яамны 78 албан хаагч, яамаар үйлчлүүлж буй 30 иргэн хамрагдсан байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээллэх журамд заасны дагуу Төрийн албаны “ХНУМТ” цахим системд бүртгэл үүсгэн, төлөвлөгөө, бүрэлдэхүүн, ёс зүйн зөрчлийн бүртгэлийг бүртгэн ажиллаж байна. "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийг эрчимжүүлэн ажиллах тухай асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны 2025 оны 08 дугаар 22-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан.</p> |                       |     |
| 3. | Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох газруудыг мэдээллээр хангаж, санал хүргүүлэх. | Хүргүүлэх мэдээллийн тоо | - | Мэдээллээр хангаж, санал хүргүүлсэн байна. | 1.Монгол Улсын Их хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 53 дугаар тогтоолын 1.8 болон 1.10 дахь хэсэгт даалгасан арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын   | 2025.01.01-2025.12.31 | 100 |

|  |  |  |  |  |   |  |
|--|--|--|--|--|---|--|
|  |  |  |  |  | <p>талаарх мэдээллийг нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 02/3117 дугаар албан бичгээр Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн.</p> <p>2. Улсын их хурлын гишүүн С.Цэнгүүний 2025 оны УИХ-03/8694 дүгээр албан бичгийн дагуу “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл, дотоод бүтцийн мэдээлэл, цалин хөлсний мэдээлэл, санхүүжилтийн хэлбэр зэрэг холбогдох мэдээллүүдийг нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/3264 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 213 дугаар тогтоолын хэрэгжилтийн мэдээлэл болон сайжруулах саналыг нэгтгэн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/3641 дүгээр албан бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.</p> <p>4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, сайжруулах саналыг 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02/4163 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>5. “Улаанбаатар хот болон томоохон суурин газруудын агаарын бохирдлыг бууруулах үйл</p> |  |
|--|--|--|--|--|---|--|

|    |   |                         |   |   |  |                           |     |
|----|---|-------------------------|---|---|--|---------------------------|-----|
|    |   |                         |   |   | ажиллагааны төлөвлөгөө"-ний төсөлд салбарын хэмжээнд тусгах саналаа 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 02/3713 дугаар албан бичгээр Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн.  |                           |     |
| 4. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллах, судалгаа, мэдээллийг гаргах. | Судалгаа -1<br>Тайлан-2 | 2023 онд зөвлөлийн гишүүнээр ажиллаж, судалгаа, тайланг дэд зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлсэн байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2025.04.23-ны өдрийн хуралдаанд оролцож, дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал хүргүүлсэн.  | 2025.01.01-<br>2025.12.31 | 100 |
| 5. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллах, судалгаа, мэдээллийг гаргах.                             | Тайлан-1                | 2023 онд зөвлөлийн гишүүнээр ажиллаж, судалгаа, тайланг дэд зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. | Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлсэн байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн хариуцсан ажлуудын биелэлтийг гарган, 2025 оны төлөвлөгөөнд санал хүргүүлж, салбарын зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны төлөвлөгөөний төслийг танилцуулах хуралд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр оролцсон. НҮБХАС-ийн захиалгаар бие даасан зөвлөх нь Монгол Улсын Засгийн газрын бүх яамд, газар, агентлагуудын Бодлого, төлөвлөлтийн газар, хэлтсийн ажилтан, мэргэжилтнүүдийн жендэрийн статистик хэрэглээг хөгжүүлэх сургалтын хэрэгцээг | 2025.01.01-<br>2025.12.31 | 100 |

|  |  |  |  |  |   |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|
|  |  |  |  |  | тодорхойлох үнэлгээний асуулгын газрын хэмжээнд бөглүүлэн, нэгтгэж яамны жендэрийн асуудал хариуцсан албан хаагчид 2025.03.26-ны өдөр хүргүүлсэн. |  |  |
|--|--|--|--|--|---|--|--|

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Шалгуур үзүүлэлт                               | Гүйцэтгэлийн түвшин |   |  |                       | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|-----|--|--|---------------------|---|--|-----------------------|--------------------------|------------------|
|     |  |  | Суурь түвшин        | Хүрэх түвшин  | Хүрсэн түвшин (биелэлт)  |                       |                          |                  |
|     | 1  | 2  | 3                   | 4   | 5  | 6                     | 7                        |                  |
| 1.  | Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сургалт, хөтөлбөрт хамрагдах.                         | 1В улирал (хавар)-д нийт 10 кредит цаг судлах. | -                   | 1В улирал (хавар)-д судлах хичээлүүдийг судалсан байна. | ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуульд БНСУ-ын засгийн газрын санхүүжилттай Монгол Улсын хот байгуулалтын дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх "S-Quad" төслийн хүрээнд хэрэгжиж буй "Хот ба бүс нутгийн төлөвлөлт" магистрын хөтөлбөрийн сонгон шалгаруулалт тэнцэн, 2024-2025 оны хичээлийн жилд элсэн суралцаж байна. 2024-2025 оны хичээлийн жилийн 1 дүгээр улиралд нийт 4 хичээлийн 10 кредит судлан голч үнэлгээ 3.7 байна. | 2025.01.01-2025.12.31 | 100                      |                  |
| 2.  | "Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад оролцох. | Сургалт-1                                      | -                   | Сургалтад оролцсон байна.                               | Монголын Криминологичдын холбооны ерөнхийлөгч, Хөгжлийн эрх зүйн төвийн удирдах зөвлөлийн дарга хуульч, судлаач Ганбатын Эрдэнэбатыг урьж 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан "Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад хамрагдсан.  | 2025.01.01-2025.12.31 | 100                      |                  |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**  
ХБОСБЗГ-ын ахлах шинжээч  
( Албан тушаал )

Б.Мөнхбаяр / *Б.Мөнхбаяр* /  
( Нэр, гарын үсэг )

.....  
( Огноо )

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
САЛБАРЫН БОДЛОГО, СТРАТЕГИ, НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН  
АХЛАХ ШИНЖЭЭЧ БЯМБА-ОЧИРЫН МӨНХБАЯРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС  
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д              | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|------------------|---|--------------------------------------|---|--------------|---|
|                  | 1   | 2                                    | 3                                       | 4            | 5   |
|                  | Оноо  | 60 хүртэл                            | 10 хүртэл                               | 70 хүртэл    |   |
| <b>Зорилт 1.</b> |   |                                      |   |              |   |
| 1.               | <b>Арга хэмжээ 1.1.1</b><br>УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.                                    | 60                                   | 10                                      | 70           |   |
|                  | <b>Арга хэмжээ 1.1.2</b><br>УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.                                       | 50                                   | 10                                      | 60           |   |
|                  | <b>Арга хэмжээ 1.1.3</b><br>"Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.   | 60                                   | 10                                      | 70           |   |
|                  | <b>Арга хэмжээ 1.1.4</b><br>УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | 60                                   | 10                                      | 70           |   |
|                  | <b>Арга хэмжээ 1.1.5</b><br>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.  | 60                                   | 10                                      | 70           |   |
|                  | <b>Арга хэмжээ 1.1.6</b><br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.  | 55                                   | 10                                      | 65           |   |

|  |   |    |    |      |  |
|--|---|----|----|------|--|
|  | <b>Арга хэмжээ 1.1.7</b><br>Монгол Улсын Ерөнхий сайдын "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 2025 оны 01 дүгээр, "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | 60 | 10 | 70   |  |
|  | <b>Арга хэмжээ 1.1.8</b><br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025-2028 оны "Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт"-ийг шинэчлэн боловсруулж батлуулах, Барилга, хот байгуулалтын яамны 2021-2024 оны "Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт"-ийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах.                                  | 60 | 10 | 70   |  |
|  | <b>Арга хэмжээ 1.1.9.</b><br>"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-д төсөл, арга хэмжээг тусгуулах ажлыг зохион байгуулах.  | 60 | 10 | 70   |  |
| <b>Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт</b> |   |    |    |      |  |
|  | <b>Үүрэг даалгавар 1.</b><br>Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах.   | 60 | 10 | 70   |  |
|  | <b>Үүрэг даалгавар 2.</b><br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах.  | 60 | 10 | 70   |  |
|  | <b>Үүрэг даалгавар 3.</b><br>Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох газруудыг мэдээллээр хангаж, санал хүргүүлэх.  | 60 | 10 | 70   |  |
|  | <b>Үүрэг даалгавар 4.</b><br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллах, судалгаа, мэдээллийг гаргах.  | 60 | 10 | 70   |  |
|  | <b>Үүрэг даалгавар 5.</b><br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллах, судалгаа, мэдээллийг гаргах.  | 60 | 10 | 70   |  |
| <b>Дундаж оноо:</b>                    |   |    |    | 68.9 |  |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|-----|----------------------------------|--------------------------------|---------------------------|---|
|     | 1                                | 2                              | 3                         | 4   |
|     |                                  |                                |                           |   |

|                    |   |  |    |
|--------------------|---|--|----|
| 1.                 | Арга хэмжээ 1.<br>Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сургалт, хөтөлбөрт хамрагдах.                        |  | 13 |
| 2.                 | Арга хэмжээ 2.<br>"Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад оролцох |  | 13 |
| <b>Дундаж оноо</b> |   |  | 13 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)**

| Д/д  | Үзүүлэлт                | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|--|-------------------------|-----------------------------------|---|
|  | 1                       | 2                                 | 3   |
| 1.   | Хандлага, ёс зүй        | 7                                 |   |
| 2.   | Дүн шинжилгээ хийх      | 7                                 |   |
| 3.   | Асуудал шийдвэрлэх      | 7                                 |   |
| 4.   | Хариуцлагатай байдал    | 7                                 |   |
| 5.   | Ажлын цаг ашиглалт      | 7                                 |   |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) |                         |                                   |   |
| 6.   | Мэргэжлийн ур чадвар 1. |                                   |   |
| 7.   | Мэргэжлийн ур чадвар 2. |                                   |   |
| 8.   | Мэргэжлийн ур чадвар 3. |                                   |   |
| <b>Дундаж оноо</b>                               |                         | 7                                 |   |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)**

| Д/д                | Үзүүлэлт         | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|--------------------|------------------|------------------------------|
|                    | 1                | 2                            |
| 1.                 | Хандлага, ёс зүй | 8                            |
| 2.                 | Багаар ажиллах   | 8                            |
| 3.                 | Харилцаа         | 8                            |
| <b>Дундаж оноо</b> |                  | 8                            |


**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д   | Үнэлгээний үзүүлэлт   | Үзүүлэлт тус бүрийн оноо  |
|---|---|---------------------------|
| 1.  | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.) | (70 хүртэлх оноо)<br>68,9 |
| 2.  | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт                                       | (15 хүртэлх оноо)         |
| 3.  | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)                                      | (7 хүртэлх оноо)<br>7     |
| 4.  | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)   | (8 хүртэлх оноо)<br>8     |
| 5.  | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)        | (..... оноо)              |
| <b>Нийт оноо =</b>  |   |                           |
| ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо |   | 96,9                      |

Үнэлгээ өгсөн:

ХБОСБЗГ-ын дарга  
(албан тушаал)

Нэгжийн дарга

  
(гарын үзэг)

/О.Одбаяр/  
(албан хаагчийн нэр)

2025.12.18 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:**

**Төрийн жинхэнэ албан хаагч:**

Ахлах шинжээч  
(албан тушаал)

*Б. Мөнхбаяр*  
.....  
(гарын үсэг)

/Б.Мөнхбаяр/  
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

**Үнэлгээг хянасан:**

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ТЗУГ-ын дарга  
(албан тушаал)

*Б. Бат-Эрдэнэ*  
.....  
(гарын үсэг)

/Б.Бат-Эрдэнэ/  
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Яамны хүний нөөц, шагнал хариуцсан  
ахлах шинжээч  
(албан тушаал)

*Л. Янжмаа*  
.....  
(гарын үсэг)

/Л.Янжмаа/  
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

**Үнэлгээг баталгаажуулсан:**

**Төсвийн шууд захирагч**

Төрийн нарийн бичгийн дарга

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

/М.Баяраа/  
(албан хаагчийн нэр)

..... (огноо).